



Христитгэлийн там бол грек үлгэр домог, фарисай уламжлал хоёрын хольмог



Тамын тухай ойлголт анх эрх баригчдын бодлогоос үүссэнийг бид өмнөх нийтлэлээс мэдэж авсан. Эртний эрх баригчид энгийн ардыг хяналтандаа байлгах гэж шашинг ашиглан, ардыг тамын шийтгэлээс айх айдсаар залж захирдаг байжээ.

Гэтэл энэ харийн шашны домог Ертөнцийн Эзэний үг болох Библид бүү хэл, Христийн чуулганд хэрхэн орсон бэ? гэсэн асуулт тавигдана.

Хариу нь Есүсийн үед иудейчүүдийн багш болсон фарисайчуудтай холбоотой.



МЭӨ 300-гаад жилийн өмнө Агуу Александер эзэнт гүрнээ байгуулаад грек соёл иргэншлийн хамт грек хэлээ хаа сайгүй дэлгэрүүлжээ. Иймд «Хуучин гэрээ»-ний грек орчуулга хэрэг болсон. Тэгэхэд

“Шеол” буюу “Үхэгсдийн орон”-г орчуулахад “Хадес” гэсэн үгийг сонгожээ.

Даанч грекчүүдийн хувьд “Хадэс” нь еврей “Шеол”-оос тэс өөр ойлголт юм.



Эртний шашны үлгэр домгийн дагуу “хүний сэтгэл үхэшгүй” бөгөөд “бие махбод нь үхсний дараа сүүдэр мэт сэтгэл нь Хадес бурхны захирдаг, газар доорх ертөнцөд очдог. Энэ үхэгсдийн орон гүн ангалаар хуваагдсан ивээлийн ба шийтгэлийн хоёр бүстэй. Муу хүний сэтгэл галтай голд тамлагдана, харин сайн хүний сэтгэл жаргалтай газар очно” гэдэгт грекчүүд итгэдэг байв.

Грек соёлд нэвчсэн олон иудейчүүд сэтгэлийн үхэшгүй мөнхийн тухай онолыг грек шашнаас ба тэрнээс ч өмнө Вавилоны шашнаас хүлээн авчээ. Үүнээс гадна Үхэгсдийн оронг ангалаар хуваагдсан хоёр тасагтай зэрэг ойлголтыг ч авч Их Эзэний сургаалтай хольж хутгасан.¹ Мөн фарисайчууд өөрийн бодлоо энэ хольмол теологидоо нэмж оруулсан. Тухайлбал: тэнгэр элч шударга хүнийг Үхэгсдийн оронд аваачих, “Абрахамын өвөр”-т суух, үхэгсэд хоорондоо ярилцах, Абрахамаас юм гуйхаар хүүхэд илгээх зэрэг. Энэ бүх ухагдахуун «Талмуд» хэмээх еврей багш нарын уламжлалт номлолд байдаг юм. Гэвч эдгээр ухагдахуун ч, ойлголтууд ч Их Эзэний Үгэнд харш байдаг бөгөөд «Хуучин Гэрээ»-нээс олдохгүй.

1 Харийн шашнаас орж ирсэн үзэл бодлыг өөрийнх болгосныг харуулдаг иудей ном Есүсийн төрсний өмнөх хэдэн зуунд олон гарсан. Тухайлбал, МЭӨ 200 онд орчим бичигдсэн, өнөө үед шинээр алдаршиж буй “Енох” хэмээх ном бий. Зохиогч нь хөрст дэлхийн цөмд очиж тэнд Үхэгсдийн орны “диваажин” ба “Гехенна” гэдэг хоёр хэсэг үзснээ бичсэн нь харийн шашны домгоос гаралтай.



Тэгсэн ч гэсэн эдгээр төсөөлөл танил сонсогдох байх. Нэг удаа Есүс там гэмээр газрын тухай сургаалт үлгэрийг фарисайчуудад ярьсан (Лук 16:19-с). Гэтэл энэ Үхэгсдийн орон гүн ангалаар хуваагдсан хоёр хэсэгтэй, нэг талд нь гал дөл дотор зовж буй баян хүн, нөгөө талд нь Абрахамын өвөрт ядуу Лазар сайхан суудаг. Энэ бол яг л грек домгийн Хадес шиг.



Тэгвэл Есүс яагаад грек Үхэгсдийн орны тухай ярьсан бэ? Яагаад “Абрахамын өвөр” зэрэг фарисай багш нарын ухагдахууныг хэрэглэсэн бэ? Есүс бас грекжүүлсэн ойлголттой байсан гэж үү? Мэдээж үгүй. Есүс Өөрөө үнэн учраас (Иохан 14:6) Түүний заасан бүхэн үнэн бөгөөд Их Эзэний Үгтэй бүрэн нийцэхээс өөр замгүй.

Есүс мөн иудей багш нарын хэллэгийг ашигласан нь тэдний хольмол теологийг сайшаасан гэсэн үг бас биш. Фарисай багш нар өөрсдийн уламжлалаа дээдлэн Их Эзэний үгнээс


илүүд үздэг нь Есүсийн бухимдлыг харин ч их хүргэдэг байсан.



Тэднийг Есүс “**Та нар уламжлан авсан ёс заншлаараа Бурханы үгийг хүчингүй болгодог**” гэж зэмлэжээ (Маарх 7:13).

Фарисайчууд өөрсдийгөө “Мосегийн дагалдагчид” гэж үздэг (Иохан 9:28) хэрнээ “**Бурхан ИАВЭ чинь та нараар сахиулж мөрдүүлэх гэж тушаасан тушаалыг би та нарт бүгдийг хэлж өгсөн. Үүн дээр юу ч бүү нэм, үүнээс юуг ч бүү хас**” гэсэн Мосегийн үгийг тэд мартсан бололтой (Дэд хууль 4:2, СМО). Тэд Их Эзэний үгэн дээр харийн шашнаас авсан тамын ойлголтуудыг нэмэхийн тулд үхлийн тухай сургаалыг нь хассан жишээтэй.

Фарисайчуудын үзлээр хүн Ертөнцийн Эзэний Хуулийг нарийн чанд сахисны төлөө Түүнээс материаллаг ивээл дүүрэн, чинээлэг амьдралыг шагнал болгон хүртдэг ба эцэст нь диваажинд ордог (Дэд хууль 28:1-14, Левит 18:5). Харин ядуурал, өвчин зэргийг тэд Ертөнцийн Эзэний эсрэг гэм үйлдсэний үр дагавар гэж үздэг байв (Дэд хууль 28:15-68).





Хуулийн гол зорилго нь Ертөнцийн Эзэнийг ба хажууд буй хүнээ хайрлах Хайр болохыг тэд даанч ойлгосонгүй. Энэрэл, шударга байдал, даруухан зан хамгаас чухал сайн үйлс болохыг тэд ухаарсангүй (Дэд хууль 6:5; Левит 19:18; Матай 22:36-40; Мика 6:8 (СМО): **“Юу нь сайн гэдгийг хүн чамд айлдсан бус уу? Юу хүсэж байгаагаа чамд ИАВЭ мэдүүлсэн биш үү? Зөв шударгыг үйлдэж, энэрэл журмыг эрхэмлэ. Өөрийнхөө Бурхантай даруухнаар алх!”**).

Тийм учраас өвчинд баригдсан, ядуу Лазар Абрахамын өвөрт суусан, харин баян хүн Хадесийн тарчилгааны хэсэгт очсон энэ өгүүллэгээрээ дамжин Есүс, ядуусыг дорд үзээд мөнгийг шүтдэг фарисайчуудыг өөрсдийнх нь үг, ойлголтоор шүүж буй хэрэг (Лук 16:14; 19:22).

Фарисайчууд өмнө нь Есүсийг буруутган “Энэ хүн чинь зөвхөн чөтгөрүүдийн захирагч Беелзебулээр ч чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг” гэхэд Есүс хариуд нь “тийм биш” гэх мэтээр маргалдаагүй харин “Хэрэв Би Беелзебулээр чөтгөрүүдийг хөөн зайлуулдаг юм бол [мэдээж тийм биш байсан!], танай хөвгүүд хэнээр чөтгөрүүдийг зайлуулдаг байх вэ?” гэж эргээд л асуулт тавьдаг (Матай 12:24-27). Яг үүнтэй адилаар Есүс тус үлгэрт гардаг тэдний уламжлалыг үгүйсгэх ч үгүй, зөвшөөрөх ч үгүй, харин тэднийг шүүх гэж шууд ашигладаг.



Фарисайчуудын уламжлал Ертөнцийн Эзэний үгнээс зөрдөг учраас буруу байх нь ойлгомжтой. Тамын тухай сургаал нь мөн адил Ертөнцийн Эзэний үгийг хүчингүй болгодог юм байна. Иймд Есүс тус үлгэрээрээ хүний мөнхийн хувь заяаг харуулах гээгүй, харин ч үхсэн хойноо ч амьдрах тухай харийн шашнаас авсан фарисайчуудын сургаалаар доог тохуу хийсэн. Энэ буруу ташаа сургаал ямар инээдэмтэй болохыг Есүс энэ үлгэрээр дамжуулан Ертөнцийн Эзэний Үгийг мэддэг хүн бүрт харуулдаг. Өөрөөр хэлбэл, баян хүн, ядуу Лазарын тухай өгүүллэг бол чадварлаг уран элэглэл буюу цэвэр ёжлолын жишээ. (Бас зөгнөлийн чанартай гүн гүнзгий утга энэ сургаалт үлгэрт бий. Гэхдээ тэрийг авч үзэх зай энд алга.)

Эцэст нь Есүс тамаас аврагдах арга замыг Абрахамаар заадаг. Тухайлбал: Мосе болон эш үзүүлэгчийг сонсох, өөрөөр хэлбэл, тэдний үгээр дамжин тамын байдаггүйг олох ёстой.



Уншигч танд тамын тухай хүний сургаалыг
Үхэгсдийн орны тухай Бүтээгч Эзэний Мосе болон
эш үзүүлэгчдээр дамжуулан хэлсэн үгтэй амархан
харьцуулах боломжийг доорх хүснэгтээр олголоо.

	ХҮНИЙ	БҮТЭЭГЧ ЭЗЭНИЙ
	үзэл бодлын дагуу	дагуу
<p>Үхэгсдийн оронд болж буй явдлыг шууд утгаар ойлгох ёстой юу, шилжсэн утгаар ойлгох ёстой юу?</p> <p>“Та нарт Мосе болон Эш үзүүлэгчид байгаа, тэднийг сонс!”</p> <p>--Есүс</p>	Үхэгсдийн оронд	Үхэгсдийн оронд
	доорх олон зүйлс болдог!	юу ч болдоггүй!
	(Лук 16)	(олон ишлэл)
	галын дөлд шатах (24)	тоос шороонд хэвтэх (Иов 17:16; Дуу. 30:9)
	хашгирах (24)	анир чимээгүй (Дуу. 115:17)
	тарчлан байх (23)	мэдэх юм байхгүй (Ном. 9:5)
	тайвшрал хүсэх (24)	юу ч бодохгүй (Дуу. 146:4)
	холоос ч гэсэн юм харах (23)	харанхуй, гүн сүүдэртэй (Иов 10:21) нүд харанхуйлсан, аниастай (Дуу 13:3)
	учирсан, учраагүй хүнийг таних (23)	Их Эзэнийг ч дурсан санахгүй (Дуу. 6:5)
	бусадтай ярилцах (24)	юу ч ярихгүй (Дуу. 31:17; 94:17)
өршөөл гуйх	Их Эзэний найдвартайг горьдох ч үгүй (Исаиа 38:18)	
тусламж гуйх (24)		
амьдралаа эргэн санах (25)	“марталтын газар” (Дуу. 88:12) дурсамж байхгүй (Дуу. 6:5; 88:12)	
гэр бүлдээ санаа зовох (28)	хайр байхгүй (Ном. 9:6) хорсол байхгүй (Ном. 9:6) атаа жөтөө байхгүй (Ном. 9:6)	





Есүс ямартай ч дагалдагч нартаа анхааруулж: **“Фарисай болон садукайчуудын хөрөнгөнөөс сэрэмжил, болгоомжил”** гэхэд тэд Түүнийг “фарисай болон садукайчуудын сургаалаас болгоомжил гэж айлдсаныг ухаарав” (Матай 16:6,12). Бид тэгвэл мөн адил фарисайчуудын гаргасан, “Абрахамын өвөр” ба “галтай там”-ын тухай сургаалыг өөрийнх болгоод үхлийн тухай Ертөнцийн Эзэний үгийг хүчингүй болгохоос сэрэмжлэх нь зөв гэсэн үг.

Садукайчууд болохоор сэтгэлийн үхэшгүйд итгэдэггүй байсан. Гэтэл тэд үхэгсэд дахин амилна гэдэгт мөн итгэдэггүй (Матай 22:23; Үйлс 23:8). Тус сургаалыг нь Есүс “үхэгсдээс хэн нэг нь амилсан ч тэд үнэмшихгүй биз дээ” гээд дээрх үлгэрээрээ мөн буруушаасан (Лук 16:31). Дахин амилалтыг үгүйсгэх нь болгоомжлоод явбал зохих буруу сургаал мөн болохыг Паул ч бичсэн (1 Коринт 15:12-19).

Тамд итгэх итгэлийн үр нөлөө

Тамын тухай сургаал анх орж ирсэн шалтгаан нь ардыг буруу зүйлээс хашраан, журамтай амьдрахад хүргэх улс төрийн бодлого. Өнөөдөр олон пасторын хувьд тамын сургаалын чухал нь бас үүнд оршдог. Сонирхолтой нь, энэ санааны үнэн эсэхийг шалгах боломжийг фарисай ба садукай нар бидэнд олгодог. Ертөнцийн Эзэний илчлэлтийг тэд адилхан мэдсэн, Мосегийн



хуулийг адилхан хүлээж авсан. Тэр хоёр бүлгийн итгэлд байсан ганц ялгаа нь “үхэшгүй сэтгэл” ба “дуусашгүй тамын шийтгэл”-д оршив. Фарисайчууд тамд итгэдэг байсан бол садикайчууд тамд итгээгүй. Тэд тамаас айлгах айдсаар захирагдаагүй гэсэн үг. Хэрэв тамд итгэх нь хүнийг үнэхээр буруу юм хийхээс сэргийлдэг бол фарисайчууд хамгийн ариун хүмүүс болж, харин садикайчууд хамгийн муу нүгэлтэн болсон байж таарна.

Гэтэл тэр хоёр бүлгийн биеэ авч явах байдлыг харьцуулахаар үнэн байдал яг эсрэгээр нь байсан. Өөрөө фарисай хүн агсан түүхч Иосеф Флавий садикайчуудыг шударга ёсыг маш хатуугаар сахьдаг бөгөөд шударга зөв явдалтай хүмүүс байсныг нь гэрчилдэг.

Гэтэл фарисайчууд ба хуулийн багш нарын амьдралыг Их Эзэн Есүс Өөрөө гэрчилсэн. Тэднийг Есүс олон удаа зэмлэж, “хоёр нүүртэн; бэлэвсэн эмэгтэйчүүдийг

дээрэмддэг; шударга ёс, энэрэл өршөөл, үнэнийг үл тоомсорлодог; хорт могой; цагаанаар будсан ч дотроо бузар ялзрал дүүрэн булш” зэргээр өөр хэнээс ч илүү муугаар дүгнэсэн. Тэд үнэхээр ариун хүмүүс байгаагүй нь тодорхой.

Гэтэл садикайчуудыг Есүс хэзээ ч ийм үгээр зэмлэж байгаагүй билээ.





Садукай бүлгийнхэн мэдээж төгс ариун хүмүүс байгаагүй ч хоёр нүүр гаргагч нараас хамаагүй дээр ёс суртахуунтай байв.

Дүгнэж хэлэхэд, “тамд итгэх нь хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс болиулж, буян хийхэд хүргэдэг” гэсэн эртний онол сургаал худлаа болж харагдана. Библийн ба түүхийн баримтын дагуу мөнхийн зовлонт тамд итгэсэн хүмүүс ариун явдалтай болохын оронд харин ч хорт могой ба ялзрал дүүрэн булш мэт байсан. Нөгөө талаар тамд итгэдэггүй хүмүүс нь журамтай амьдралаар замнасан. Тамд мөнхөд зовохоос айх нь хүнийг ариун амьдрахад хүргэдэггүй. Нөгөө талаар тамд итгэдэггүй байх нь хүнийг ёс суртахуунгүй амьтан болгодоггүй.

Чуулганы эцгүүд тамыг заадаг болжээ

Тамын тухай сургаал эртний шашнаас үүсч, иудейчүүдийн багш нараар заагддаг байгаад зогсоогүй, яваандаа Христийн чуулганд орж ирсэнийг бид мэднэ. Есүсийн элч апостол нар Ертөнцийн Эзэний үгийг дагаж, үхлийг нойрсохтой адил болохыг заадаг байсан. “Өглөө” буюу дахин амилалт ирэхээр үхэгсэд биеэрээ босож, сэтгэлээрээ сэрж ухаан орох болно гэсэн үг.

Гэвч чуулганы зарим удирдагч “Христийн доторх эгэл байдлаас” (2 Коринт 11:3) төөрч эхэллээ. Афин хотын Атенагорус гэдэг “чуулганы эцэг”



2-р зууны эцэст Христийн сүмд “хүний бие үхсэн ч сэтгэл нь үхэшгүй” болохыг зааж эхэлсэн. Тэрээр фарисайчуудын адилаар Ертөнцийн Эзэний үгийг грек гүн ухаантай хольж хутгаад алдарт Платоны сургаалыг илүүд үзсэн учраас тэр. Дээр нь иудейжүүлэгчдийн нөлөө байсан байж магад (Үйлс 15:5; Галат 2:14).

Хүний сэтгэл мөхөшгүй гэдэгт итгэвэл бие махбод нас барсны дараа сэтгэл нь хаашаа очих талаар бодох нь зайлшгүй дагалдах хэрэг. МЭ 240 оны үед хуульч мэргэжилтэй байж “чуулганы эцэг” болсон Картаг хотын Тертуллиан анх удаа мөнхийн зовлонгийн тухай сургаалыг Христийн сүмд оруулсан бололтой. Итгэгчид Ертөнцийн Эзэнд дуулгавартай хандан, ариун амьдралаар амьдрах нь түүнд маш чухал байв. Иймд “ивээгдсэн хүмүүсийн сэтгэл мөнхөд жаргахын зэрэгцээ ёрын муу хүмүүсийн сэтгэл мөнхөд тарчлах болно” гэж зааж эхэлсэн юм. Дуулгаваргүй хүн дуусашгүй ял эдлэх нь Тертуллианд шударга санагдсан.



Тертуллиан шиг теологчид Библийн олон ишлэлийг тамын сургаалд “тааруулж” тайлбарладаг болсон. Эцэст нь тус сургаал МЭ 553 онд болсон Католик сүмийн зөвлөлд “Христитгэлийн үндсэн зүйл”-д батлагдсан юм.



Энэ балиар онол сургаал Христитгэлд бүрэн зөвшөөрөгдтөл 500 жил болсон. Үүний дараа дайснуудаа мөнхийн галд шатаах бурхныхаа үлгэр дуурайллыг Католик сүм дагадаг болж мянган жилийн турш олон сая “тэрс үзэлтэн”-ийг аймшигтайгаар хавчиж тамлан алдаг байв.

Протестант шинэчлэл 16-р зуунд католик сүмийн олон сургаалаас салсан боловч тамын тухай сургаалыг нь хадлалж ирсэн. Тус сургаалыг үнэн гэж бодсон орчуулагч нар Библи орчуулахдаа “там” юмуу “мөнхийн зовлон” гэдэг үгийг теологчдийн тодорхойлсон ишлэлд хэрэглэжээ. Өнөөдөр ихэнх итгэгчийн итгэл Их Эзэний үгэнд биш, өөр шашнаас орж ирсэн хүний гүн ухаант уламжлалд тулгардаг нь үнэхээр харуусам хэрэг.

Хоёр нүүртэй болгох чөтгөрийн сургаал

“Хэн нэг нь та нарыг Христийн дагуу биш, харин... хүний уламжлалын дагуух гүн ухаан болон хоосон мэхлэлээр олзлох вий хэмээн сэрэмжлэгтүн” гэж Паул биднийг анхааруулдаг (Холоссай 2:8). Тамын тухай сургаал “хүний уламжлалын дагуух гүн ухаан” мөн.

Мөн Христийн чуулганд орж ирэх “чөтгөрийн сургаал”-аас Паул болгоомжилсон (1 Тимот 4:1). Мөнхийн зовлонгийн тухай сургаал Ертөнцийн Эзэний Үгийг эсэргүүцэн, хүчингүй болгодог учраас яах ч аргагүй чөтгөрийн сургаал мөн.



Хүн Ертөнцийн Эзэний тухай юунд итгэдэг нь асар чухал. Тэр итгэл өөрийн эрхгүй зан чанарт нь нөлөөлнө.



Мөнхийн зовлонгоос зайлсхийх зорилготой фарисайчуудын хувьд зөвт хүн байх туйлын чухал байлаа. Тэдний ойлголтоор Бичвэрүүдийг нарийн судалж,

хуульд заасан зан үйл бүрийг ёсоор үйлдсэн нь зөвт хүн. Гэвч фарисайчууд чухам хайр энэрлийг гээжээ. Мөнхийн зовлонгийн тухай тэдний сургаал Их Эзэний шударгыг хайр энэрлээс нь салгахад хүргэсэн учраас тэр.

Өнөөдөр ч тийм өрөөсгөл ойлголттой христитгэлт хүмүүс олон бий. *“Их Эзэн шударга учраас дуулгаваргүй муу хүнийг заавал шийтгэх ёстой. Тэр шийтгэл нь мөнхөд үргэлжлэх зовлон байхаас өөр аргагүй”* гэж заах нь олонтаа. Энэ нь Ертөнцийн Эзэний хайр энэрлийг орхиж, үнэн шударга ёсыг гуйвуулсан хэрэг биш гэж үү?

Зөв шударга чанар, хайр энэрэл хамтдаа Бүтээгч Эзэний зан чанарын үндэс учраас Түүний төлөвлөгөөнд салшгүй холбоотой болохыг бид хэзээ ч мартаж ёсгүй (Дуулал 85:10).



Есүсийн дүгнэснээр фарисайчуудын шашинлаг байдалд хайр энэрэл хослосон үнэн зөв шударга чанар лав алга (Матай 5:20).

Тэд Их Эзэний биш, өөрсдийнхөө л зөвт байдлыг тогтоохыг эрмэлздэг гэсэн Паулын дүгнэлт юутай үнэн билээ (Ром 10:3). Үр дүнд нь тэд хоёр нүүртэй, хуурамч зантай болжээ.

Бас зөвт хүний дүр л исгэдэг фарисайчуудын сургаалаас зогсохгүй, мөн тэдний **“исгэсэн хөрөнгө мэт хуурамч зангаас**

болгоомжлогтун!” хэмээн

Есүс дагалдагч нараа сануулсан юм (Лук 12:1, ББ).

“Исгэсэн хөрөнгө” удалгүй гурилыг нэвт шингэдгийн адилаар хоёр нүүрт байдал бидний зүрх сэтгэлд халдан нэг мэдэхэд эзэмшсэн байх



аюултай гэж Есүс бидэнд ч гэсэн анхааруулдаг.

Энэ бол бодитой сануулга. Фарисайчуудын мөрөөр замнагч олон итгэгчид өнөөдөр даанч адилхан ойлголттой, адилхан эрмэлзэлтэй явна. Үр дүнд нь фарисайчуудаас ялгаагүй хуурамч зантай итгэгч өнөөдөр мөн олон бий.

Христийг үнэн сэтгэлээс хайрладаг бид үнэнийг мэдээд оюун санааг минь чанга атгадаг байсан гажаа үлгэр домгийн хүлээснээс ангижрах цаг хэдийн болсон байна.



Тамын зовлон муу санаанаас зохиосон үлгэр учраас хэн ч тамд орж тамлагдах талаар бид айх хэрэггүй. “Та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө” гэж Есүс амласан (Иохан 8:32). Түүний үнэн Үгийг улам сайн чагнах боломжтой цаг өнөөдөр хэдийнэ ирсэн байна.

Хонин сүргээ айдсаар биш, хайраар хөтөлдөг Сайн Хоньчинд өөрийгөө даатган, Түүний хэлснээр явж, бидэнд олгож өгсөн Түүний л зөвт байдалд бүрэн найдацгаая. □

Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Орчуулга тодруулаагүй тохиолдолд АБ-с авсан гэсэн үг.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Dawson, S. G. (1943). The rich man, Lazarus, and the afterlife.

www.truthaccordingtoscripture.com.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org